



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/832

Ховд

Төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хэрэгжүүлэх төсөлд оролцох орон нутгийн оролцоо, санал санаачлагыг дэмжих /KFW, TNC- төслийн хэрэгжих газрын барилга буулгалтын зардал/-н ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Гулз майнинг транс” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хэрэгжүүлэх төсөлд оролцох орон нутгийн оролцоо, санал санаачлагыг дэмжих /KFW, TNC- төслийн хэрэгжих газрын барилга буулгалтын зардал/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цолмонбаатар

- Стандарт хэмжилзүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Б.Түмэнжаргал

- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж

- Аймгийн архивын тасгийн дарга

И.Нямаа

- “Гулз майнинг транс” ХХК-ий захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн

2. “Гулз майнинг транс” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/- д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН